

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Нийгмийн даатгалын санд 2018 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах төсвийн хэмжээ, төсөв зарцуулах эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль тогтоомж

2.1.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хууль тогтоомж нь Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН
ОРЛОГО, ЗАРЛАГА**

3 дугаар зүйл.Эрүүл мэндийн даатгалын санд 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай.

Д/д	Орлогын төрөл		Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд		
		1.1.Аж ахуйн нэгж, байгууллагаас төлөх шимтгэл	97,695.4
		1.2.Ажиллагсдаас төлөх шимтгэл	119,572.2
	1.3.Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл		36,192.0
		1.4.Төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцах иргэний эрүүл мэндийн даатгалын шимтгэл	67,723.8
		1.5.Бусад даатгуулагчаас төлөх шимтгэл	15,501.2
		1.6.Бусад орлого	39,327.3
	Нийт орлого		376,011.9

4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчид доор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

Д/д	Зарлагын төрөл		Дүн /сая төгрөгөөр/
1	Эрүүл мэндийн сайд		